



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 09 өдөр

Дугаар A/52

Улаанбаатар хот

┌ Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хянан  
шийдвэрлэх Дэд ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх заалт, Ерөнхий сайдын 2022 оны 214 дүгээр захирамжийн 5 дугаар хавсралт, нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар баталсан "Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам", Газрын даргын 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хууль, тогтоомжийн хүрээнд судлан үзэж, шийдвэрлэх ажлыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 25-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулах Дэд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:

Д.ӨЛЗИЙСАЙХАН

(Байгаль, орчны стандартын хэлтсийн дарга)

ГИШҮҮД:

Б.ЖАРГАЛ

(Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хууль, эрх зүй хариуцсан Ахлах мэргэжилтэн)

М.ГАЧМАА

(Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтсийн мэргэжилтэн)

Б.ХУЛАН

(Байгаль орчны станандартын хэлтсийн мэргэжилтэн)

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА


Ч.ЭНХТАЙВАН

(Бичиг хэргийн ажилтан)

2. Ерөнхий сайдын 2022 оны 214 дүгээр захирамжийн 5 дугаар хавсралтаар баталсан Ажлын хэсгийн ажиллах нийтлэг удирдамжийг баримтлан, дээд шатны байгууллагад тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ



1150500273